<table>
<tr><td colspan="3">Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/</td></tr>
<tr><td colspan="3">Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</td></tr>
<tr><td colspan="3"></td></tr>
<tr><td colspan="2">Тайлагнах хугацаа</td><td>2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдөр</td></tr>
<tr><td colspan="2">Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</td><td>Компанийн нэр: Айтүүлс ХК<br>УБГД: 9010001141<br>Үнэт цаасны код: 543<br>Утас: 75755585<br>Имэйл: info@itools.mn, secretary@itools.mn<br>Фэйсбүүк: Айтүүлс ХК</td></tr>
<tr><td colspan="2">Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</td><td>Монголын хөрөнгийн бирж</td></tr>
<tr><td colspan="2">Бизнесийн үйл ажиллагааны салбар</td><td>Мэдээллийн технологи, харилцаа холбоо /Дата төвийн үйлчилгээ/</td></tr>
<tr><td colspan="2">Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</td><td>34,452,124</td></tr>
<tr><td colspan="2">Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</td><td>Нягтлан бодогч: Б.Өнөрбадрах<br>Борлуулалтын мэргэжилтэн: Т.Энхмаа<br>ТУЗ-ийн н/б дарга: Г.Янжинлхам<br>Гүйцэтгэх захирал: Ч.Мөнхжаргал</td></tr>
<tr><td colspan="3"></td></tr>
<tr><td>1.</td><td colspan="2">Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</td></tr>
<tr><td></td><td>Санхүүгийн байдлын үзүүлэлт</td><td rowspan="4">2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг Нэгдүгээр хавсралтаар хүргүүлэв.</td></tr>
<tr><td></td><td>Орлогын тайлан</td></tr>
<tr><td></td><td>Өмчийн өөрчлөлтийн тайлан</td></tr>
<tr><td></td><td>Мөнгөн гүйлгээний тайлн.ан</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | |
| 2. | *Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт* | |
| | Айтуулс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит хурлаар Айтуулс ХК-ийн 2024 оны нэгдүгээр хагас жилийн тайланг хэлэлцэнэ. | |
| 3. | *Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт* | |
| 3.1. | *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/* | Цэвэр ашгийн хувь 6.0%<br>Өөрийн хөрөнгийн өгөөж 2.6%<br>Нийт хөрөнгийн өгөөж 2.1%<br>Нэгж хувьцаанд ногдох ашиг 3.07<br>Эргэлтийн харьцаа 5.36<br>Түргэн хөрвөх чадварын харьцаа 4.36 |
| 3.2. | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт* | |
| 3.3. | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл* | Хавсралтаар хүргүүлэв. |
| 3.4. | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого* | Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй. |
| 4. | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/* | |
| | Тайлант хугацаанд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй. | |
| 5. | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл* | |

| | |
|---|---|
| | Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй. |
| *5.* | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл* |
| | Компани нь ХЭЭХ-ыг 4-р сарын 19-ны өдөр танхимаар амжилттай зохион байгуулж, хурлын тайлан материалыг СЗХ болон МХБ-д хүргүүлсэн. Тус хурлаар ТУЗ-ийг дараах бүрэлдэхүүнтэй сонгосон бөгөөд ТУЗ нь дарга болон Хороодын гишүүдийн хуваарилалтыг хийсэн.<br>**Айтүүлс ХК-ийн ТУЗ-ийн гишүүд, хороод:**<br>1. ТУЗ-ийн дарга Г.Хатанболд<br>ТУЗ-ийн ердийн гишүүн А. Баттамир<br>ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Бүнчинсүрэн<br>ТУЗ-ийн ердийн гишүүн Л.Золбаяр<br>ТУЗ-ийн ердийн гишүүн Ч.Мөнхжаргал<br>ТУЗ-ийн ердийн гишүүн З.Төрболд<br>ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Гантуяа<br>ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Жавхлан<br>ТУЗ-ийн хараат бус гишүүн З.Саранчимэг<br>2. Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны дарга гишүүд:<br>Дарга: Н.Жавхлан /хараат бус гишүүн/<br>Гишүүд: Г.Гантуяа /хараат бус гишүүн/, Л.Золбаяр /хараат бус гишүүн/<br>3. Аудит, мэдээллийн аюулгүй байдлын хорооны дарга, гишүүд:<br>Дарга: Г.Гантуяа /хараат бус гишүүн/<br>Гишүүд: З.Саранчимэг /хараат бус гишүүн/, Д.Бүнчинсүрэн /ердийн гишүүн/<br>4. Бизнес хөгжлийн хорооны дарга, гишүүд:<br>Дарга: З.Төрболд /ердийн гишүүн/<br>Гишүүд: Н.Жавхлан /хараат бус гишүүн/, З.Саранчимэг /хараат бус гишүүн/, Г.Гантуяа /хараат бус гишүүн/, А.Баттамир /ердийн гишүүн/<br>5. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга<br>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Жаргал нь жирэмсний болон амаржих, хүүхэд асрах чөлөө авсан тул Г.Янжинлхамыг 3-р сарын 01-ний өдрөөс эгүүлэн томилсон. Г.Янжинлхам нь Компанийн засаглалын сургалтад сууж, гэрчилгээ авсан, компанийн засаглалын чиглэлээр ажлын туршлагатай болно. |
| *6.* | *Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл* |
| | Шинээр байгуулагдсан ТУЗ нь Компанийн дүрэм, журамд заасны дагуу улиралд нэг удаа ээлжит хурал хийхээр төлөвлөсөн ба 5-р сарын 7-ны өдөр анхны хурлаа хийж, 2-р улирлын тайланг хэлэлцэх хурлыг 7-р сарын 17-ны өдөр хийхээр төлөвлөн ажиллаж байна. |

Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх явцыг дотооддоо үнэлэх Компанийн засаглалын үнэлгээний тайланг СЗХ-нд 6-р сард хүргүүлсэн бөгөөд 2024 онд багтаан засаглалыг сайжруулах ажлуудыг төлөвлөн ажиллаж байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Чимэдхишигийн Мөнхжаргал

Албан тушаал: "Айтүүлс" ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг: ……………………………………………

(Тамга/тэмдэг)

Овог, нэр: ……………………………………………

Албан тушаал: "......................." ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: …………………………………………..

(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Янжинлхам

Албан тушаал: Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: ……………………………………………

i tools

## “Айтүүлс ХК”-ийн

# 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН




*Unlimited Possibilities*

# Агуулга

- Бизнесийн үйл ажиллагаа
- Санхүүгийн үзүүлэлтүүд
- Онцлох үйл явдлууд
- Компанийн засаглал



# 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**Зах зээлд анхдагч Техникийн дэмжлэгийн үйлчилгээг нэвтрүүллээ**.

Айтүүлс компани нь дата төв, программ хангамж, мэдээлэл технологийн чиглэлээр **2011** оноос үйлчилгээ үзүүлж байгаа билээ. Домэйн нэрийн бүртгэл, веб хост, сервер байршуулалт, виртуал серверийн түрээс, бизнес и-мэйл зэрэг нийт үндсэн 12 үйлчилгээг зах зээлд үзүүлдэг бөгөөд үндсэн үйлчилгээний хэрэглэгчдийн санал хүсэлт, хэрэглэгчдэд тулгардаг асуудлыг шийдвэрлэх зорилгын хүрээнд 2024 оны эхний хагас жилд **Техникийн дэмжлэгийн үйлчилгээг** зах зээлд анхдагч болгон нэвтрүүллээ.

Түүнчлэн 2024 оны эхний хагас жилд нийт идэвхитэй үйлчилгээний тоо **19,107** болж өмнөх оны мөн үеэс **11%** өсөлттэй, Нийт бүртгэлтэй хэрэглэгчийн тоо **14,662** болсон байна.

Дижитал шилжилт өдрөөс өдөрт хурдацтай явагдаж байгаа өнөө үед хэрэглэгчиддээ дижитал бүтээгдэхүүн үйлчилгээг цогцоор хүргэх болсон **2024 оны эхний хагас жилийн** онцлох үйлчилгээ билээ.

2024 оны эхний хагас жилийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал



# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал

## Борлуулалтын орлого




## Цэвэр ашиг




## Орлого, үр дүнгийн хураангуй тайлан / Аудитлагдаагүй/

| | 2022 H1 | 2023 H1 | 2024 H1 |
|---|---|---|---|
| **Борлуулалтын орлого** | **1,700.8** | **1,906.8** | **1,877.9** |
| Борлуулалтын өртөг | 1,007.0 | 1,277.9 | 1,342.6 |
| **Нийт ашиг** | **693.8** | **628.9** | **535.2** |
| Бусад орлого | 33.5 | 25.3 | 34.9 |
| Удирдлагын болон ҮА-ны зардал | 708.6 | 446.2 | 452.4 |
| Татварын өмнөх ашиг | 18.8 | 208.0 | 117.8 |
| Татварын зардал | 2.0 | 21.6 | 12.1 |
| **Цэвэр ашиг** | **16.7** | **186.4** | **105.6** |

# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал

## Нийт актив, пассив




## Санхүү байдлын тайлан /Аудитлагдаагүй/

| Хөрөнгө /сая төгрөг/ | 2022 H1 | 2023 H1 | 2024 H1 |
|---|---|---|---|
| Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 240.1 | 315.6 | 371.7 |
| Дансны ба бусад авлага | 546.4 | 1,037.4 | 985.6 |
| Бараа материал ба бусад эргэлтийн хөрөнгө | 226.6 | 314.3 | 310.6 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 3,579.3 | 3,535.1 | 3,393.8 |
| **Нийт хөрөнгө** | **4,592.5** | **5,202.3** | **5,061.8** |

| Өр төлбөр болон эздийн өмч /сая төгрөг/ | | | |
|---|---|---|---|
| **Өр төлбөр** | **1,071.83** | **1,241.50** | **1,046.35** |
| Богино хугацаат өр төлбөр | 74.8 | 244.5 | 311.4 |
| Урт хугацаат өр төлбөр | 997.0 | 997.0 | 734.9 |
| **Эздийн өмч** | **3,520.63** | **3,960.82** | **4,015.42** |
| Өмч | 1,481.4 | 1,481.4 | 1,481.4 |
| Нэмж төлсөн капитал | 763.1 | 763.1 | 763.1 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 460.7 | 460.7 | 460.7 |
| Хуримтлагдсан ашиг | 815.4 | 1,255.5 | 1,310.1 |
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **4,592.5** | **5,202.3** | **5,061.8** |

# 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛУУД



“Айтүүлс” ХК-ийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаа амжилттай зохион байгууллаа. Уг хурлаар 7 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.




“Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн № 24/004 тоот тогтоолоор компанийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгийн **43 /дөчин гурав/** хувь буюу **103,356,372** төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлэлээ. Тус шийдвэрийн дагуу нэгж хувьцаа тус бүрд **3 /гурван төгрөг/** төгрөгөөр тооцож ногдол ашгаа хувьцаа эзэмшигчдэдээ хуваариллаа.



Дата төв, программ хангамж, мэдээлэл технологийн үйлчилгээ үзүүлэгч “Айтүүлс” ХК-н Техникийн үйл ажиллагааны хэлтсийн менежер Ч. Гансүлд ISO/IEC 27001:2022 МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН менежментийн тогтолцооны олон улсын “**Тэргүүлэх аудитор**” болж, гэрчилгээгээ гардан авлаа.



**ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны стандарт болон SO/IEC27001:2013 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартын** Магадлан Аудит хийгдэж бөгөөд аливаа үл тохиролгүй, **Сайн** гэсэн үнэлгээтэйгээр гэрчилгээгээ үргэлжлүүлэн эзэмших дүгнэлт гарлаа.




Айтүүлс ХК нь 2012 оноос эхлэн cPanel удирдлагын панелтэй ВЕБ БАЙРШУУЛАХ үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж эхэлсэн. Тэгвэл өнгөрөгч 2023 оны 11 сард Айтүүлс ХК -н инженерүүд cPanel & WHM System Administrator I Certification Level 1, Level 2, cPanel-Certified-Partner-Accreditation түвшнүүдийн болзлыг хангаж сертификат авсанаар Айтүүлс ХК cPanel компанийн АЛБАН ЁСНЫ PARTNER боллоо.




**ISO/IEC27001:2013 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандар**тын хэрэгжилтийг үнэлэх зорилгоор Олон улсын сургалт, баталгаажуулалтын Мон Майнинг Сертификейшин ХХК-аас 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Айтүүлс ХК-д Магадлан Аудит хийсэн бөгөөд аливаа үл тохиролгүй, САЙН гэсэн үнэлгээтэйгээр гэрчилгээгээ үргэлжлүүлэн эзэмших дүгнэлт гарлаа.

# КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Айтүүлс компани нь Монгол Улсад мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр **2011 онд** үүсгэн байгуулагдсан бөгөөд 2012 оноос эхлэн **домэйн нэрийн бүртгэл, веб хост, сервер байршуулалт, виртуал серверийн түрээс, и-мэйл сервисийн ашиглалт** зэрэг интернет технологид суурилсан бүтээгдэхүүн, үйчилгээг аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүст үзүүлж тэдгээрийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг ханган ажилласаар ирсэн. Компани нь өнгөрсөн 11 жилийн хугацаанд мэдлэг чадвартай ажилтан, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нийлүүлэн салбарынхаа тэргүүлэх компани болохыг зорьж ажилласан ба 2017 оны 09 сараас эхлэн өмчийн хэлбэрээ өөрчлөн, **хувьцаат компани** болсон.

## Эрхэм зорилго

Дижитал орчны үнэ цэнийг хүчирхэгжүүлэх найдвартай суурь нь байна.

## Алсын хараа

Дэлхийн жишигт нийцсэн дата төвд хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, эргэлзээгүй сонголтыг бий болгоно.

## Үнэт зүйлс

**Бид - Үнэнч хариуцлагатай**

Бид дэлхийд өрсөлдөх чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэхдээ ямагт үнэнч байж цаг хугацаандаа хариуцлагатай үйлчилгээг үзүүлдэг хамт олон.

**Бид – Чадварлаг**

Бид мэдээллийн технологийн чиглэлээр өндөр түвшинд бэлтгэгдсэн чадварлаг хамт олон.

**Бид - Эелдэг**

Бид хэрэглэгч нартаа цаг ямагт эелдэг боловсон хүнлэг хандаж, тулгарсан асуудлыг нь шийдэхдээ ямагт найрсаг үйлчилгээг үзүүлдэг баг, хамт олон.

**Бид - Стандарт хэрэгжүүлэгч**

Бид хууль эрх зүйн хэм хэмжээг нягт сахин баримталж зохих стандарт горимын дагуу хэрэглэгч, харилцагчийн эрэлт хэрэгцээг бүрэн хангасан үйлчилгээ үзүүлдэг хамт олон.

**Бид -Хурдан шуурхай**

Бид харилцагч, хэрэглэгчийн хүссэн цаг хугацаанд хүссэн үйлчилгээ, тулгарсан асуудал, хүсэлт, саналыг эн тэргүүнд харгалзан үздэг шуурхай хамт олон.

**Бид - Бүтээлч**

Бид ямагт шинэлэг оновчтой санааг бүтээгдэхүүн үйлчилгээндээ нэвтрүүлдэг бүтээлч хамт олон

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ /ЦААШИД "ТУЗ"/, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Айтүүлс ХК-ийн **Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)** нь ердийн 6, хараат бус 3, нийт 9 гишүүнээс бүрдэж, Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ТУЗ нь 2024 оны эхний хагас жилд 3 удаа ээлжит болон ээлжит бус хурал, 1 удаа эчнээ санал хураалт явуулан нийт 11 тогтоол гаргасан.

Компани нь ХЭЭХ-ыг 4-р сарын 19-ны өдөр танхимаар амжилттай зохион байгуулж, хурлын тайлан материалыг СЗХ болон МХБ-д хүргүүлсэн.

Шинээр сонгогдсон ТУЗ нь 2024 оны 5 сарын 07-ны өдөр ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу анхны ээлжит хурлаа зохион байгуулж ТУЗ-ийн дарга болон дэргэдэх хороодыг байгуулан гишүүдийн хуваарилалтыг хийсэн.


ТУЗ-ийн дарга **Г.Хатанболд**


ТУЗ-ийн ердийн гишүүн **А. Баттамир**


ТУЗ-ийн ердийн гишүүн **Л.Золбаяр**


ТУЗ-ийн ердийн гишүүн **Ч.Мөнхжаргал**


ТУЗ-ийн ердийн гишүүн **Д.Бүнчинсүрэн**


ТУЗ-ийн ердийн гишүүн **З.Төрболд**


ТУЗ-ийн хараат бус гишүүн **Г.Гантуяа**


ТУЗ-ийн хараат бус гишүүн **Н.Жавхлан**


ТУЗ-ийн хараат бус гишүүн **З.Саранчимэг**

**ВЕБ САЙТ:** www.itools.mn

**УТАС:** 7575-5585

**И-МЭЙЛ:** info@itools.mn

***ХЯЗГААРГҮЙ БОЛОМЖ***



2024 он